



ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА: 2020 ОНЫ 6- 10 САР



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨГ: 14.060.000

### Төсөл хэрэгжсэн газар

Архангай аймаг Ихтамир сум

### Төслийн зорилго

Малын нэмэгдэл тэжээлийн нөөц бүрдүүлэх замаар бэлчээрийн даац ачааллыг бууруулах.

### Төслийн зорилтууд

СБАХ-ы дэргэдэх анхан шатны хоршооны эзэмшлийн 20 га талбайд БАХ-ийн ахлагчид болон малчид хамтран ногоон тэжээл тариалах.

### Үйл ажиллагаа

Төслийн хүрээнд Ихтамир сумын 9 БАХ-ийн ахлагчид хамтран 20 га атаршсан талбайн хашааг засварлан 2020 оны 07 сарын 1-5-ны хооронд хувийн техник бүхий иргэн аж ахуй нэгжээр тариалалтыг хийлгүүлсэн.

Мөн 2020 оны 09 сарын 26-аас 10 дугаар сарын 05-ны хооронд

ногоон тэжээл хураах ажлыг малчид хамтран зохион байгуулсан.

### Төслийн хөрөнгө оруулалт

Төсөл хэргжүүлэхэд нийт 10 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байсныг НАМЭМ төсөл болон СБАХ, хоршоо, малчдаас хамтран хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж хэрэгжүүлсэн болно.

Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Санхүүжилт, төгрөг
Төслөөс	3.000.000
ОНХС	0
СБАХ	500.000
Малчид	6.560.000
<b>Нийт</b>	<b>10,060,000</b>



### Зураг

Ногоон тэжээл хураалтын үйл явц



### Зураг

Тэжээл ачилт, тээвэрлэлтийн явц

**Сургам: COVID 19** цар тахал болон бусад шалтгааны улмаас тэжээлийн үрийн хомсдол үүссэн зэрэг, орон нутагт худалдаалагдаж буй үрээс сонголтгүй авч тариалалт хийсэн нь ургац төлөвлөсөн хэмжээнд хүрч ургаагүй. Цаашид үрийг лабораторын шинжилгээгээр батлагдсан сайн чанарын үр худалдаж авах хэрэгтэй гэдгийг мэдсэн.

### Хөрөнгө оруулалтын зарцуулалт

Төслийн санхүүжилтийг юунд зарцуулсан талаар доорх хүснэгтэнд мэдээлэл оруулна

№	Хөрөнгө оруулалтын зарцуулалт	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
1	Үр худалдаж авах	тн	3.6	850.000	3.060.000
2	Хөрс боловсруулалт, тарилт	Га	20	300.000	6.000.000
4	Тэжээл хураалтын зардал	Га	20	50,000	1,000,000
	<b>Нийт</b>				<b>10.060.000</b>

### Борлуулалт, үйлчилгээний орлого

Төсөл хэрэгжсэнээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн үйлчилгээ, тэдгээрээс олсон орлогын талаар энэ хүснэгтэнд мэдээлэл оруулна.

№	Бүтээгдэхүүн, үйлчилгээ	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
1	Ногоон тэжээл	тн	30	350000	10,500,000
	<b>Нийт</b>				

төслийн хүрээнд нийт 30 тнн ногоон тэжээл бэлтгэж зах зээлийн ханшаас 10-15 %-ийн хямдралтай үнээр малчдад борлуулсан

### ТӨСЛИЙН ҮР ДҮН

Төсөл хэрэгжихээс өмнөх үетэй харьцуулахад төсөл хэрэгжсэнээр гарсан үр дүнгүүдийг тодорхой тоо баримттай, график дүрстэй оруулна. Үүнд:

- ↑ борлуулалт нэмэгдсэн байдал,
- ↑ шинээр бий болсон бүтээгдэхүүн,
- ↑ шинээр бий болсон хөрөнгө,
- ↑ цэвэр ашиг,
- ↑ нийгмийн ашиг тус,
- ↑ амьжиргааны түвшин, орлого нэмэгдсэн байдал,
- ↑ шинээр нэмэгдсэн ажлын байр,
- ↑ үр шим хүртсэн хүмүүсийн тоо г.м

## ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧ

Төслийн үр шимийг хүртэгч Их-тамир сумын Алтан сандал БАХ-ийн ахлагч малчин Ганхуяг: Одоо цагт малын нэмэгдэл тэжээл зайлшгүй шаардлагатай болж байна. Тэр тусмаа 2020 онд бол байгалийн хадлан гарсангүй, бэлчээрийн ургац тачир, сийрэг, мал бүрэн тарга хүчээ авч чадсангүй тиймээс малчид бид өөрсдийн хүчээр тэжээлээ ингээд тариад хураагаад авчихвал зардлын хувьд хямд төсөр, чанартай тэжээл бэлтгээд авах юм даа.

## ТӨСЛИЙН ЗОРИУЛАЛТ

Ногоон тэжээл тариалах